

Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

2022 оны жилийн эцсийн байдлаар

2022 оны 12 дугаар сарын 02

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	
9. ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ								
13	Хотын төвлөрлийг задгалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.	9.3.4. Олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудалтай байна.	2021 - 2025	678,700.0		Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/900 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний 7 ажлын жагсаалтыг баталсан. Дээрх ажлын 3 дугаар заалтад "Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх урьдчилсан ТЭЗҮ" боловсруулах, 5 дугаар заалтад "Дүүжин тээврийн төслийн нарийвчилсан ТЭЗҮ" боловсруулах, 6 дугаар заалтад "Дүүжин тээвэр төслийн Баянхошуу-Ханын материал Гэмтлийн эмнэлэг чиглэлийн зорчигчийн нягтрал, ашиг алдагдлын тооцоо судалгаа" боловсруулах ажлууд тус тус хийгдсэн. НХААГ-21/226 тоот гэрээтэй "Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх урьдчилсан ТЭЗҮ", НХААГ-21/229 тоот гэрээтэй "Дүүжин тээвэр төслийн Баянхошуу-Ханын материал Гэмтлийн эмнэлэг чиглэлийн зорчигчийн нягтрал, ашиг алдагдлын тооцоо судалгаа" боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлууд ажлын даалгаврын хүрээнд 100 хувь бүрэн дууссан тул акт үйлдэж гэрээг дүгнэж НЗДТГ-т албан тоотоор хүргүүлсэн. Харин НХААГ-21/228 тоот гэрээтэй "Дүүжин тээврийн төслийн нарийвчилсан ТЭЗҮ" боловсруулах ажлыг "Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн" НҮТББ, "Жоншт уул" ХХК нь хийж гүйцэтгэж дууссан хэдий ч Нийслэлийн засаг даргын орлогч Ж.Сандагсүрэнгээс 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 02-01/2353 дугаартай албан бичгээр Пома Эжис концерциумтай давхцаж байгаа тул төсвийн тодотголоор дахин оруулах талаар мэдэгдсэн. Үүнтэй холбогдуулан төслийн үйл ажиллагаа Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж дээр үргэлжлэн явагдаж трасс сонгох судалгааны ажлыг гүйцэтгэх шатандаа байна.	Хүрсэн түвшин, үр дүн	50
1. 2021 онд Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр автобусны дундын зогсоолыг 3 багц болгон хувааж гүйцэтгэсэн бөгөөд 1 багц ажлын төндөр нь 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр явагдаж "Өргөн говь" ХХК шалгарч Их хүрээ гудамжны урд, хойд байршилд "Мандала хотхон" нэртэй 2 зогсоолыг хийхээр болсон. Цаг хугацааны хувьд								

тендер нь зарлагдаагүй удаж хүйтэрсэн тул 2022 онд хийгдэхээр хойшилсон байсан. 2022 оны 06 дугаар сарын 20-ны дотор хийж дуусгахаар ажиллаж байсан боловч автобусны зогсоолын байршилд 18 ширхэг ногоон байгууламж, цахилгаан шугам сүлжээний 4 ширхэг кабель давхцаж байгаа тул байршилд карма гаргах боломжгүй болсон тул Сонгинохайрхан дүүргийн Далангийн зам дагуу хийхээр болсон.

2.УИХ-ын гишүүн Ц.Мөнх-оргилын санаачилагаар Сүхбаатар дүүргийн 11-20 дугаар хороонд байрлах чиглэлийн тээврийн хэрэгслийн 15 дундын, 2 эцсийн зогсоолыг тохижуулах ажлыг “Үүлэн сүндэр” ХХК нь 2021 оноос хойш эхлэн гүйцэтгэж байна. Иж бүрэн тохижуулах Бэлхийн эцэс, Тоосгоны эцсийн 2 зогсоолын ажил бүрэн дууссан ба 15 дундын зогсоолын ажил хийгдэж гүйцэтгэл 60 хувьтай байна.

3.УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар гишүүний санаачилагаар Зам тээврийн сайдын багцаар Чингэлтэй дүүргийн Хайлааст, Дэнжийн мянтын авто замд чиглэлийн тээврийн хэрэгслийн 19 зогсоолыг тохижуулахаар “Цагаан толгойн нуур” ХХК шалгарч 6 зогсоолын ажлыг хийж дууссан ба ажлын гүйцэтгэл 20 хувьтай байна.

4.Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар Чингэлтэй дүүргийн 17, 18-р хороонд Чингэлтэйн 5.1 км авто замыг шинэчлэх ажлын хүрээнд 2 эцсийн зогсоол, 17 дундын зогсоолыг тохижуулах ажлын зураг төсөлд саналаа тусгуулан ажиллаж байна. Зам талбайн ажил одоогоор эхлээгүй байна.

5.Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/259 дүгээр захирамжаар 2022 онд Нийслэлийн гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдийн тав тухтай зорчих нөхцөлийг хангах үүднээс 6 эцсийн зогсоол, 36 дундын зогсоолыг тохижуулах саналыг 2022 оны 02 дугаар сарын 28 ны өдөр 2/233 дугаартай албан бичгээр, мөн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 2/536 дугаартай албан бичгээр 100 зогсоолын байршлыг тогтоож Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсэн.

Нийслэлийн иргэдийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр “Нийтийн тээврийн үйлчилгээнд эрс шинэчлэлт хийх” талаар танилцуулга бэлтгэн, богино эргэлтийн чиглэлүүдийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд зорчигчдын дамжин суултын 7 терминал болон автобус буцаж эргэх авто замын зохион байгуулалтыг хийх шаардлагатай саналыг Нийслэлийн Засаг даргын ахлах зөвлөх Д.Мөнх-Эрдэнэд, мөн 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Засгийн газар, Улсын их хурлын гишүүдтэй хийх уулзалтын үеэр богино эргэлт хийх чиглэлүүдийн

						дамжин суулт хийх терминал байгуулах шаардлагатай талаар тус тус танилцуулсан. Улаанбаатар хотын түржрэлийг бууруулах ажлын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний богино эргэлтийн чиглэлүүдийн төлөвлөлтийг боловсруулан, үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд чиглэлийн тээврийн хэрэгсэл эргэхэд зориулагдсан терминал байгуулах байршлын саналыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 2/1290 дугаартай албан бичгээр Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.	
Хэрэгжилтийн дундаж хувь/50%*1/							
50							

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.БОЛОРЦЭЦЭГ